



## “ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРПП” ХК-ИЙН ХӨНДЛӨНГИЙН АУДИТ ТОМИЛОХ ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү Хөндлөнгийн аудит томилох журам /цаашид “Журам” гэх/-ын зорилго нь “Тэнгэрлиг Медиа Групп” ХК /цаашид “Компани” гэх/-ийн санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргийг гүйцэтгэх хараат бус, хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгон шалгаруулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмыг Аудитын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 сарын 7-ны өдрийн 162 тоот тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын кодексе, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актад нийцүүлэн боловсруулав.
- 1.3. Хөндлөнгийн аудитор нь сонирхлын зөрчлөөс ангил, бие даасан, хараат бус, мэргэжлийн өндөр ур чадвартай байна.

### ХОЁР. ХАРААТ БУС АУДИТЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. Сонгон шалгаруулалтыг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан явуулна.
- 2.2. Гүйцэтгэгчээр аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хараат бус аудитын хуулийн этгээдийг томилно.
- 2.3. Хараат бус аудитыг сонгон шалгаруулах үйл явцад Төлөөлөн удирдах зөвлөл дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
  - Тухайн жилд хараат бус аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэх ерөнхий мэдээллийн жагсаалт гаргах;
  - Аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хараат бус аудитын хуулийн этгээдүүдийн жагсаалт гаргах;
  - Хараат бус аудитын хуулийн этгээдээр санхүүгийн тайланд аудит хийлгэх ерөнхий мэдээллийг багцалж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх;
- 1.4. Төлөөлөн удирдах зөвлөлөөс хараат бус аудитаар аудит хийлгэх талаар оруулсан асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэмжсэн тохиолдолд шалгалт хийлгэх асуудлыг тодорхойлон хөндлөнгийн аудитын байгууллагыг томилно.

### ГУРАВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД БАРИМТЛАХ ШАЛГУУР

- 3.1. Хөндлөнгийн аудитораар томилох хуулийн этгээдийг доорх үзүүлэлтүүдэд авсан нийт оноогоор сонгон шалгаруулна. Үүнд:
  - 3.1.1. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан;
  - 3.1.2. Аудитын үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй;
  - 3.1.3. Аудитын хуулийн этгээдийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар;

